



ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 10 сарын 08 өдөр

Дугаар А/64

Чингис хот

Байгууллагын дэргэдэх эцэг эхийн
зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2, 18.1.6, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | |
|-----------------|---|
| Зөвлөлийн дарга | Нийгмийн бодлогын хэлтсийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудал хариуцсан мэргэжилтэн |
| Гишүүд | Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Хүний нөөцийн мэргэжилтэн |
| | Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн мэргэжилтэн |
| | Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Худалдаа үйлчилгээ, хүнс хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн бодлого хариуцсан мэргэжилтэн |
| | Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн |
| | Хууль эрх зүйн хэлтсийн Дотоод ажил хариуцсан мэргэжилтэн |
| | Цэргийн штабын офицер |

2. Зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөө гарган байгууллагын ажилчдын хүүхдүүдийн боловсрол, эрүүл мэнд, хүмүүжил төлөвшилттэй холбоотой асуудлаар эцэг эх болон багш, сурган хүмүүжүүлэгчтэй хамтран ажиллаж хүүхдийг аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх аюулгүй орчинд өсөж хөгжихөд нь дэмжлэг туслалцаа үзүүлэхийг эцэг эхийн зөвлөл /Г.Уянга/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР

231030339